



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/155


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /хурандаа Д.Дамдинцэрэн/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/-д тус тус даалгасугай.


Ш.НЯМДОРЖ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2019 оны 08 дугаар сарын 01-ны
өдрийн 4/35 дугаар тушаалын хавсралт

АЛБАДАН ЭМЧЛЭХ ЭМНЭЛГИЙН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Албадан эмчлэх эмнэлэг /цаашид “эмнэлэг” гэх/-т эмчлүүлж буй этгээд өөрт болон бусдад аюул учруулах эрсдэлийг бууруулах, үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Эмнэлгийн харуул хамгаалалтыг зохион байгуулах, албадан эмчлүүлж буй хүн /цаашид “эмчлүүлэгч” гэх/-д хяналт тавихдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын олон улсын гэрээ, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү журмыг удирдлага болгоно.

Хоёр. Эмчлүүлэгчийг эмнэлэгт хүргэх, хүлээн авах

2.1. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц эмчлүүлэгчийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргэнэ.

2.2. Албадан эмчлүүлэх санал гаргасан албан тушаалтан эмчлүүлэгчийг шүүхийн танхимаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүлээлгэн өгөх ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ.

Гурав. Харуул хамгаалалтын зохион байгуулалт

3.1. Эмчлүүлэгчийг олон нийтээс тусгаарлан, тэднээс согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, журмыг мөрдүүлэх, эмнэлэг, алба хаагчдын болон эмчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хамгаалалтын алба гүйцэтгэнэ.

3.2. Хамгаалалтын ажилтнуудыг эмнэлгийн дарга, харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга нар өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж, нэгтгэн зохион байгуулна.

3.3. Эмнэлгийн харуул хамгаалалтыг дараах төрлөөр зохион байгуулна:

3.3.1. байнгын;

3.3.2. хүч нэмэгдүүлсэн;

3.3.3. өндөржүүлсэн бэлэн байдлын;

3.4. Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаа байнгын хамгаалалтад байна.

3.5.Хуулиар тогтоосон нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрүүдэд, шаардлагатай бусад үед эмнэлгийн даргын шийдвэрээр хүч нэмэгдүүлсэн хамгаалалтад шилжин ажиллана.

3.6.Эмнэлэгт онцгой нөхцөл бий болсон үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллана.

3.7.Хүч нэмэгдүүлсэн, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд эмчлүүлэгчдийн зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

3.8.Хүч нэмэгдүүлсэн хамгаалалт болон өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах шийдвэрт түүний үргэлжлэх хугацаа, эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх үүрэг, дотоод цагийн хуваарь, эмчлүүлэгчид тавих хяналт, харуул хамгаалалтыг хэрхэн зохион байгуулах тухай болон эмнэлгийн эргүүл, жижүүрийн бүрэлдэхүүний томилгоог тодорхой тусгана.

3.9.Эмнэлэгт бий болсон дараах нөхцөл байдлыг онцгой нөхцөлд тооцно:

3.9.1.эмчлүүлэгчийн зүгээс бусдын амь бие, эрүүл мэнд, эрх чөлөөнд хүч хэрэглэн халдах үйлдэл гаргасан, эмнэлгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг эвдэж сүйтгэсэн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болсон, эмчлүүлэгч оргосон;

3.9.2.эмнэлгийн дотоод журам, алба хаагчийн шаардлагыг зохион байгуулалттайгаар эсэргүүцсэн, нийтийг хамарсан суулт, өлсгөлөн зарласан;

3.9.3.гамшиг, аюулт үзэгдэл гал түймэр, хүчтэй салхи, усны үер зэрэг байгалийн онц үзэгдэл тохиолдсон, эсхүл олон хүнийг хамарсан хордлого, гоц халдварт өвчин гарсан;

3.9.4.эмчлүүлэгчийг эмнэлэгт хүргэх үед хүч хэрэглэн халдсан, осол болсон;

3.10.Эмнэлгийн дарга онцгой нөхцөл байдал бий болсон үед ажиллах төлөвлөгөөг батална.

3.11.Эмнэлгийн хамгаалалтыг дараах хүч хэрэгслээр зохион байгуулна:

3.11.1.эмнэлгийн хамгаалалтын ажилтан, албан хаагчид, бусад хүч хэрэгсэл;

3.11.2.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны харуул хамгаалалтын хэлтэс, түүний хүч хэрэгсэл;

3.11.3.цагдаа, орон нутгийн засаг захиргааны зэрэг бусад байгууллагын хүч хэрэгсэл.

3.12."Хамгаалалтын хүч хэрэгсэл" гэдэгт эмнэлгийн хамгаалалтын болон бусад мэргэжлийн ажилтнууд, тусгай хэрэгсэл, хамгаалалтын бүс, тэдгээрийн техник, тоног төхөөрөмж, албаны нохой, болзошгүй ажиллагааны үед ажиллах төлөвлөгөө болон хуулийн дагуу явуулж буй бусад ажиллагааг хамааруулна.

3.13.Эмнэлэгт үүссэн онцгой нөхцөл байдлыг таслан зогсоох чиг үүрэг бүхий бүлгийг эмнэлгийн даргын шийдвэрээр байгуулж болно.

3.14.Эмчлүүлэгчийг нийтэд үйлчилдэг болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт яаралтай шилжүүлэх тохиолдолд харуул хамгаалалттайгаар эмнэлгийн мэргэжилтэн, эмчийн хяналтад шилжүүлнэ.

3.15.Эмнэлгийн харуул хамгаалалттай холбоотой төлөвлөгөө, хоногийн жижүүрийн илтгэл, танилцуулга, харуул хамгаалалтад хөтлөгдөх бүртгэл, заавар, журмын хуудасны тоо ширхэгийг дугаарлан нууцалж, дууссан тохиолдолд хуульд заасан хугацаанд архивт шилжүүлж хадгална.

Дөрөв.Эмнэлгийн хамгаалалтын бүс

4.1.Эмнэлгийн хамгаалалтын бүсэд эмчлүүлэгчийн байр, өрөө тасалгаа, нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ болон сургалтын байр, аж ахуйн хашааг тойруулан тогтоосон анхааруулга бүхий тэмдэгт шон, зурвас зэргийг тус тус хамааруулан ойлгоно.

4.2.Хамгаалалтын бүсийн бүрэн бүтэн байдлыг эмнэлгийн харуул хамгаалалтын бүрэлдэхүүн хариуцаж, өдөр тутамд үзлэг хийж хүлээлцэнэ.

4.3.Эмнэлэг нь гэрэлтүүлэг, дүрс бичлэгийн төхөөрөмжтэй байх бөгөөд харуул хамгаалалтад дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, албаны нохой ашиглаж болно.

4.4.Дүрс бичлэгийн төхөөрөмжийг эмнэлгийн барилга, байгууламж, зам талбай, нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ болон сургалтын байр болон шалган нэвтрүүлэх байр, эмчлүүлэгчийн өрөө, хонгил, шатны хонгил, тусгаарлах тасалгаа, эргэлт уулзалтын байр болон эмнэлэгт орох, гарах хөдөлгөөнийг хянах боломжтойгоор байрлуулна.

4.5.Эмнэлэг нь хамгаалалтын хашаатай байна. Хамгаалалтын хашааны дээд ирмэгт торон саадтай байж болно.

4.6.Хамгаалалтын хашааны гадна болон дотор хамгаалалтын бүс, дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг харуул хамгаалалтын бүрэлдэхүүн хариуцаж, ээлжийн дарга хяналт тавина.

Тав.Эмнэлгийн хоногийн жижүүрлэлт, эмчлүүлэгчид тавих хяналт

5.1.Харуул хамгаалалтын бүрэлдэхүүн нь ээлжийн дарга, шалган нэвтрүүлэх хамгаалалтын ажилтан, даалгавар гүйцэтгэгч хамгаалалтын ажилтан, бичлэгийн хяналтын ажилтан, холбоочин, сувилагчаас бүрдэнэ.

5.2.Харуул хамгаалалтын бүрэлдэхүүний хуваарийг эмнэлгийн дарга батлах ба хамгаалалтын ажилтнуудыг техник хэрэгсэл, нэг бүрийн тусгай хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд бусад цэргийн болон мэргэжлийн албан хаагч, дадлага, сургуулилтад хамрагдаж байгаа мэргэжлийн сургуулийн сонсогчийг үйл ажиллагаанд татан оролцуулж болно. Мөн шаардлагатай үед эмнэлгийн даргын шийдвэрээр нэмэлт эргүүл, жижүүрийг томилж ажиллуулж болно.

5.3.Хамгаалалтын үүргийг 24 цагаар тасралтгүй гүйцэтгэх ба шаардлагатай гэж үзвэл үүрэг гүйцэтгэх хугацааг эмнэлгийн байршил, нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээний онцлогийг харгалзан өөрөөр тогтоож болно.

5.4.Мансуурах донтой эмчлүүлэгчийг согтуурах донтой эмчлүүлэгчээс тусад нь байрлуулж, хариуцсан хамгаалалтын ажилтан хяналт тавина.

5.5.Нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээ болон сургалтыг эмнэлгийн байршилд харуул хамгаалалт дор зохион байгуулна.

5.6.Эмнэлгийн харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга харуул хамгаалалтын бүрэлдэхүүнд тухай бүр үүрэг даалгавар өгөх ба жижүүрийн илтгэлтэй биечлэн танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

Зургаа.Харуул хамгаалалтын бүрэлдэхүүний үүрэг

6.1.Ээлжийн дарга дараах үүргийг гүйцэтгэнэ:

6.1.1.харуул хамгаалалтын бүрэлдэхүүнийг удирдлага зохион байгуулалт, үүрэг чиглэлээр хангаж, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих;

6.1.2.эмчлүүлэгчидтэй холбогдолтой бүртгэл, судалгааг хөтлөх,

6.1.3.эмчлүүлэгчдийн өрөө, тасалгаанд үзлэг хийж хураагдсан эд зүйлийг энэ журмын заасны дагуу шийдвэрлэх;

6.1.4.тусгаарлах тасалгаанд тусгаарлагдаж буй эмчлүүлэгчид хяналт тавих;

6.1.5.эмнэлгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, галын аюулаас урьдчилан сэргийлэх;

6.1.6.эмнэлгийн удирдлагаас өгсөн үүргийг гүйцэтгэх;

6.2.Шалган нэвтрүүлэх хамгаалалтын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ:

6.2.1.ээлжийн даргын өгсөн үүрэг, даалгаврыг цаг тухайд нь гүйцэтгэх, шалган нэвтрүүлэх байраар дамжин өнгөрөх хүний хөдөлгөөнд хяналт тавьж, бүртгэх, тэдгээрийн биед үзлэг хийх, хураагдсан эд зүйлийг энэ журамд заасны дагуу шийдвэрлүүлэх;

6.2.2.эмнэлгийн байр, өрөөнд дэг журам сахиулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

6.2.3.бусад нэмэгдэл үүргийг гүйцэтгэх;

6.3.Даалгавар гүйцэтгэгч хамгаалалтын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ:

6.3.1.эмчлүүлэгчдэд байнгын хяналт тавих, тэдний үг яриа, үйл хөдлөл, өрөөнөөс орох, гарах хөдөлгөөнийг хянах;

6.3.2.эмчлүүлэгчийн бие, эд зүйлд үзлэг хийх, хориглосон эд зүйлийг хурааж энэ журамд заасны дагуу шийдвэрлүүлэх;

6.3.3.удирдлага болон ээлжийн даргын өгсөн нэмэгдэл үүргийг гүйцэтгэх;

6.3.4.бусад нэмэгдэл үүргийг гүйцэтгэх;

6.4.Дүрс бичлэгийн хяналтын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ:

6.4.1.дүрс бичлэгийн техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцан жижүүрийн бүрэлдэхүүнийг мэдээллээр хангах, илэрсэн зөрчлийг ээлжийн дарга болон холбогдох албан тушаалтанд түргэн шуурхай мэдэгдэх;

6.4.2.дүрс бичлэгийн хяналтыг тасралтгүй тавьж, зөрчил бүхий хөдөлгөөнийг бүртгэж, тэмдэглэл хөтлөх;

6.4.3.дүрс бичлэгийн хөдөлгөөнийг ээлжийн даргад цаг тутамд мэдээлэх;

6.4.4.шаардлагатай тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацааны бичлэгийг хуулбарлаж, удирдах албан тушаалтанд танилцуулах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

6.4.5.дүрс бичлэгийн хяналтын өрөөнд эрх бүхий албан тушаалтнаас бусад гадны хүнийг нэвтрүүлэхгүй, хяналтын өрөөг эзэнгүй орхихгүй байх;

6.4.6.бусад нэмэгдэл үүргийг гүйцэтгэх;

6.5.Холбоочин дараах үүргийг гүйцэтгэнэ:

6.5.1.холбоо, мэдээллийн техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцан, удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангаж, мэдээллийг шуурхай дамжуулах;

6.5.2.мэдээг бүртгэн эмнэлгийн дарга, холбогдох албан тушаалтанд танилцуулан, хариуг шуурхай илтгэх;

6.5.3.алба хаагчид холбооны хэрэгслээр дүрмийн дагуу харьцаж байгаад хяналт тавих;

6.5.4.харьяалан удирдах байгууллагад нөхцөл байдлыг тогтоосон хугацаанд илтгэх;

6.5.5.бусад нэмэгдэл үүргийг гүйцэтгэх;

Долоо.Эмчлүүлэгчийн бие, эд зүйлд үзлэг хийх

7.1.Хамгаалалтын ажилтан эмчлүүлэгчийн бие, өрөөнд ямар ч үед үзлэг хийж болно.

7.2.Эргэлтээр оруулж буй эд зүйлд тухай бүр үзлэг хийнэ.

7.3.Эмчилгээнд харшлах, эмнэлэгт нэвтрүүлэхийг хориглох эд зүйлсийн жагсаалтыг эмнэлгийн дарга батална.

7.4.Эмэгтэй эмчлүүлэгчийн биед эмэгтэй алба хаагч эсхүл эмч, эрэгтэй эмчлүүлэгчийн биед эрэгтэй алба хаагч үзлэг хийнэ.

7.5.Үзлэгээр илэрсэн хориотой эд зүйлсийг хураан авч тэмдэглэл үйлдэнэ.

7.6.Хураан авсан эд зүйлсийн талаар эмнэлгийн дарга, харуул хамгаалалт эрхэлсэн дэд дарга нарт танилцуулж дараах байдлаар шийдвэрлэнэ.

7.6.1.түргэн гэмтэж муудах болон орчин тойронд аюул учруулж болох эд зүйлийг эмнэлгийн даргын шийдвэрээр байгуулагдсан комисс устгах ба энэ тухай тэмдэглэл хөтөлж, тухайн хүнээр гарын үсэг зуруулна;

7.6.2.бусад эд зүйлсийг зориулалтын байр, саванд хадгалж, эмчилгээнээс чөлөөлөгдөх үед нь буцаан олгох, эсхүл ар гэрт нь хүлээлгэн өгнө;

7.7.Хураагдсан эд зүйлийг ар гэрт болон бусад этгээдэд хүлээлгэн өгөхдөө эмчлүүлэгчийг байлцуулан эд зүйлийн нэр, тоо, хэмжээг тэмдэглэлд тодорхой тусгаж, хүлээн авч буй хүний биеийн байцаалтыг үндэслэж гарын үсэг зуруулан баталгаажуулж өгнө.

Найм.Эмчилгээ хийлгэхээс үндэслэлгүйгээр татгалзсан этгээдийг албадан эмчлэх

8.1.Эмчлүүлэгч эмчилгээ хийлгэхээс үндэслэлгүйгээр татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд түүнд хамгаалалтын ажилтны хяналт дор эмчийн заавраар албадан эмчилгээг хийж, энэ тухай өвчний түүхэнд тэмдэглэнэ.

8.2.Энэ журмын 8.1-д заасан албадан эмчилгээг хийхдээ Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэнэ.

Ес.Хамгаалалтын ажилтан тусгай хэрэгсэл хэрэглэх

9.1.Эмнэлгийн хамгаалалтын ажилтан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 293 дугаар зүйлд заасан нэг бүрийн тусгай хэрэгслээр хангагдана.

9.2.Эмчлүүлэгчийн зүгээс алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцэх, танхайрах, догшин авирлах, бусадтай зодолдох, эмх замбараагүй байдал үүсгэх, халдан довтлох зэргээр өөрийн болон бусдын амь нас, бие махбодид гэмтэл учруулах үйлдэл хийсэн, оргосон, оргохоор завдсан зэрэг зайлшгүй нөхцөл байдлын үед хамгаалалтын ажилтан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.

9.3.Хамгаалалтын ажилтан эмчлүүлэгчид тусгай хэрэгслийг хэрэглэхээс өмнө урьдчилан сануулах ба нэн тэргүүнд хэрэглэхгүй байхыг эрмэлзэнэ. Энэ журмын 9.2-т зааснаас бусад тохиолдолд тусгай хэрэгсэл хэрэглэхгүй.

9.4.Тусгай хэрэгсэл хэрэглэх явцад хүний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, шууд захирагдах дарга, цагдаа, эмнэлгийн байгууллагад, шууд захирагдах дарга нь прокурорт даруй мэдэгдэнэ.

9.5.Эмнэлгийн дотоод журам ноцтой зөрчсөн, эмчилгээ хийлгэхээс татгалзсан, энэ журмын 9.2-т заасан үйлдэл гаргасан бол тусгаарлах аргыг хэрэглэж болно.

9.6.Тусгаарлах, номхотгох арга болон тусгай хэрэгсэл хэрэглэсэн тухай тэмдэглэл үйлдэж өвчтөний түүхэнд хавсаргах ба эмнэлгийн даргад танилцуулна.

Арав.Харуул хамгаалалтад хориглох зүйл

10.1.Эмнэлгийн алба хаагчид дор дурдсан үйлдэл, эс үйлдэхүй гаргахыг хориглоно.

10.1.1.эмчлүүлэгчийн эмчилгээний болон хувийн нууцыг задруулах;

10.1.2.эмнэлэгт үнэт эдлэл, бэлэн мөнгө, гар утас, холбооны бусад хэрэгсэл, төлбөр тооцооны цахим хэрэгсэл, согтууруулах ундааны зүйл, мансууруулах бодис, тэсрэх дэлбэрэх болон түргэн шатамхай бодис, зэвсгийн

чанартай ашиглах болох эд зүйлс болон зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, бичлэгийн төхөөрөмж зэргийг нэвтрүүлэх, дамжуулах;

10.1.3.эмчлүүлэгчтэй хувийн харьцаа тогтоох, худалдаа хийх, захидал, эд зүйл дамжуулах, зөвшөөрөлгүй утсаар яриулах;

10.1.4.эмнэлгийн хамгаалалтын бүсэд удирдах ажилтны шийдвэрээр нэвтрэх зөвшөөрөл авснаас бусад хүнийг нэвтрүүлэх;

10.1.5.зөвшөөрөлгүйгээр хяналт тавьж буй объектоо орхих, эрх бүхий албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг, даалгаврыг зөрчих, биелүүлэхээс татгалзах;

10.1.6.эмчлүүлэгчийг зөвшөөрөлгүйгээр хамгаалалтын бүсээс гаргах, бусадтай уулзуулах;

10.1.7.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон жижүүрийн үүрэг гүйцэтгэхээс өмнө 24 цагийн дотор архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, эмчлүүлэгчээр хувийн ажил хийлгэх;

10.1.8.эмнэлгийн даргын баталсан үүрэг гүйцэтгэх хуваарийг зөрчих;

10.1.9.дур мэдэн эмчлүүлэгчийн өрөөг солих;

10.1.10.эмнэлгийн хамгаалалтын үйл ажиллагааны дүрс бичлэгийг зөвшөөрөлгүй хуулбарлан бусдад дамжуулах;

10.2.Харуул хамгаалалтад хориглох зүйлсийг зөрчсөн буруутай алба хаагчид хууль журамд заасны дагуу хариуцлага тооцно.

Арваннэг.Бусад зүйл

11.1.Эмчлүүлэгч албадан эмчлүүлж байх хугацаандаа гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, цагдаа, прокурор, шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

11.2.Албадан эмчлэх эмнэлэгт эмчилгээнд хамрагдсан хүний мэдээллийн нэгдсэн санг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба хариуцан хөтөлнө.